

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ АЛТАН НАР ТАЛБАЙД 23 Г/Т АЛТНЫ АГУУЛГА БҮХИЙ 17 МЕТРИЙН ИНТЕРВАЛ ОГТОЛЖ, ХӨНДИЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛБАЙД ХАР МОРЬ ХАЙГУУЛЫН БҮСИЙГ ТЭЛЛЭЭ

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа, Халифакс хот
2020.02.04

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” буюу “Компани” гэх) нь 2019 оны 4-р улиралд Алтан Нар, Хөндий, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийгдсэн хайгуул, өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулж байна.

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: “2019 оны 12-р сард хийсэн хайгуулын хөтөлбөрөөр Алтан Нар-д газрын дөт гүнд 50 г/т-оос дээш алтны агуулга бүхий хэд хэдэн интервал огтолж, эерэг үр дүн танилцууллаа. Энэхүү үр дүнгээр Нээлтийн Бүсийн өндөр агуулгатай цөмийг өмнө зүгт тэлж, ирээдүйд Алтан Нарын нөөцөд эерэгээр нөлөөлж болох шинэ боломжуудыг тодорхойлов.

Алтан Нарын үр дүн, 2019 оны 3-р улиралд Баян Хөндийн өмнө зүгт тэлсэн талбай болон Хар Морь талбайд 88 г/т хүртэлх хэд хэдэн өндөр агуулга бүхий эрдэсжилт үргэлжлүүлэн илрүүлсэн нь Хөндий Алтны Дүүргийн ирээдүйн төлөвийг харуулж байна. Бид жилд 60,000 унц алтыг илээр олборлох боломжтой, өндөр агуулга бүхий Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу хөгжүүлэхээс гадна нөөцийг нэмэгдүүлэх өрөмдлөгийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.”

Онцлох мэдээлэл (Хавсралт зурагтай танилцана уу):

- Алтан Нар (Алт-полиметаллын нөөц):
 - Өрөмдлөгөөр Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий цөмийг тэлэв.
 - Өрөмдлөгөөр 17 г/т алтны агуулга бүхий 23 метрийн интервал огтолсон бөгөөд үүний 7 метрийн интервал нь 70 метрийн босоо гүнд 45.7 г/т алт, 93.4 г/т мөнгө, 1.54% хар тугалга, 3.4% цайрын агуулгатай байсан (TND-135).
 - 12.2 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал огтолсон ба үүний 2 метр нь 52.9 г/т алтны агуулгатай байсан (TND-134) нь “Gap Zone” (“Урьд нь өрөмдлөг хийж байгаагүй талбай”)-ийн өмнө бүсэд өндөр агуулга бүхий эрдэсжилт байгааг баталлаа.
 - 4.68 г/т алтны агуулга бүхий 10 метрийн интервал (TND -138) зэрэг үр дүнгүүд багтаж байгаа нь алтны өндөр агуулга бүхий эрдэсжилт “Gap Zone”-ийн хойд хэсэг байгааг батлав.
 - TND-136 цооногоор хүдэржилт өмнө зүгт нээлттэй болохыг баталгаажууллаа.
- Хар Морь (Алт):
 - 2019 оны 4-р улирлын эхээр илрүүлсэн 32.9 г/т алтны агуулга бүхий чулуун дээж авсан газрын ойролцоо тус бүр нь 87.8 г/т, 18.2 г/т, 15.3 г/т, 12.1 г/т алтны агуулгатай чулуун дээжүүдийг илрүүлсэн.
 - Хөрсний геохимийн дээжлэлт болон зураглалын ажлаар алтны эрдэсжилт бүхий талбайн хэмжээг 1.5км х 2км болгон тэлэв.

- Улаан (Зэс-Алт):
 - Алт агуулсан турмалины брекчийн хоолойг огтоллоо.

2020 оны хайгуулын хөтөлбөрийн хураангуй:

- Хэтийн төлөв бүхий талбайнуудад өнөөг хүртэл хийсэн бүх ажлыг нэгтгэн нягталж, мэргэжилтнүүдийн өгсөн зөвлөгөө, тайлалд тулгуурлан 2020 оны хайгуулын хөтөлбөрийг боловсруулж байгаа бөгөөд 2-р улиралд эцэслэхээр төлөвлөж байна.

Баян Хөндий ордыг олборлолтын шат руу шилжүүлэхээр ажиллаж буй энэ үед Эрдэнэ Ресурс нь 2019 оны хайгуулын хөтөлбөрийн үр дүнг танилцуулан, Баян Хөндий (“Bayan Khundii”) ордтой ойр орших хайгуулын хэтийн төлөв бүхий талбай, Хар Морь (“Dark Horse”), Алтан Нар (“Altan Nar”) талбайн нөөцийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Баян Хөндий ордоос хойш 16 км зайд орших Алтан Нар ордын Нээлтийн бүс дээр нарийвчилсан судалгаа, загварчлалыг хийснээр өмнөх өрөмдлөгийн хөтөлбөрөөр огтлогдсон нэн өндөр агуулга бүхий эпитеpmаль буцлалтын бүс байж болох эрдэсжсэн давхаргыг шалгах төлөвлөгөөг боловсрууллаа. Түүнээс гадна 2019 оны 4-р улиралд Хар Морь талбайн гадаргуугаас 89 г/т алтны өндөр агуулга бүхий эрдэсжилт үргэлжлүүлэн илрүүлж, талбайг 1.5км X 2км болгон тэлсэн. Энэ нь газрын дөт гүнд хийгдсэн өрөмдлөгөөр 70 г/т алт бүхий 2 метрийн интервал илрүүлсэн Алтан Арроу талбайтай зэргэлдээ оршдог.

2020 оны бидний гол зорилт бол хэтийн төлөв бүхий эдгээр гурван талбайд нөөцийг нэмэгдүүлэх бөгөөд 2019 онд хийгдсэн өрөмдлөгийн хөтөлбөрийг нэгтгэн, хянасны дүнд 2020 оны 2-р улирлын хээрийн ажил болон оны дунд үед хийгдэх өрөмдлөгийн хөтөлбөрийг боловсруулна.

Алтан Нар орд

Эрдэнэ Ресурсийн 100% эзэмшдэг Алтан Нар төслийн 5.6 км эрдэсжсэн бүсэд багтаж буй 18 хэтийн төлөв бүхий талбайн нэг талбайд 2019 оны 4-р улиралд нийт 667 тууш метр өрөмдлөгийн судалгаа хийсэн. Энэ төсөл нь эцсийн ТЭЗҮ боловсруулж, ашиглалтад шаардлагатай зөвшөөрлүүдийг авахаар ажиллаж буй Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 16 км-т оршдог. Тус өрөмдлөгийн хөтөлбөрөөр эпитеpmаль буцлалтын бүс (epithermal boiling zone) байж болох өндөр агуулга бүхий алтны эрдэсжилттэй давхаргыг амжилттай шалгасан бөгөөд тус алтны өндөр агуулга бүхий бүсийг тэлж чадсанаар ирээдүйн нөөцийн тооцоонд эерэгээр нөлөөлөх боломжтой боллоо. Нээлтийн бүсэд урьд нь өрөмдлөг хийж байгаагүй талбайд (“Gap Zone”) өндөр агуулга бүхий цөмийг судлахаар дөрвөн цооног өрөмдсөн. Ордыг өмнө зүгт тэлэх боломжтой талбайг тав дахь цооногоор шалгасан.

Хүснэгт 1 – Алтан Нард гүйцэтгэсэн өрөмдлөгийн ажлын үр дүнгийн хураангуй

Цооног	-ээс	хүртэл	*Цооногт хэмжигдсэн зузаан	Au г/т	Ag г/т	Pb %	Zn %
TND-134	101.0	111.0	10.0	12.2	21.0	0.55	1.18
үүнд	105.0	107.0	2.0	52.9	59.5	1.77	3.80
TND-135	97.0	120.0	23.0	17.0	44.7	0.75	1.47
үүнд	105.0	112.0	7.0	45.7	93.4	1.54	3.40
үүнд	105.0	106.0	1.0	108.0	81.0	1.16	2.79
үүнд	106.0	107.0	1.0	52.9	135.0	3.80	6.22
үүнд	108.0	109.0	1.0	52.8	149.0	1.50	3.10

үүнд	117.0	120.0	3.0	14.5	23.3	0.83	0.98
TND-136	84.0	86.0	2.0	0.99	0.0	0.14	0.24
ба	110.0	126.0	16.0	0.37	0.9	0.11	0.24
TND-137	6.0	13.0	7.0	2.64	11.1	0.66	0.43
ба	20.4	23.0	2.6	0.89	5.4	0.28	0.38
ба	69.0	73.0	4.0	1.76	9.0	0.10	0.24
TND-138	20.0	28.0	8.0	1.72	1.8	0.03	0.09
ба	40.0	44.0	4.0	1.54	4.3	0.17	0.17
ба	56.0	66.0	10.0	4.68	50.8	0.31	0.73

* TND-134, TND-135 ба TND-136 цооногт огтлогдсон хүдрийн бүсийн жинхэнэ зузаан нь цооногт хэмжигдсэн зузааны ~72%, TND-137 ба TND-138 цооногт огтлогдсон хүдрийн бүсийн жинхэнэ зузаан нь цооногт хэмжигдсэн зузааны ~45% болно гэж тооцоолсон.

TND-134 цооногийг Нээлтийн Бүсийн зүүн хойш чиглэсэн үргэлжлэл, мөн шинээр илрүүлсэн өндөр агуулга бүхий цөмийг давхар шалгахар өрөмдсөн. Тус цооног нь 12.2 г/т алт, 21.0 г/т мөнгө, 0.55% хар тугалга, 1.18% цайр (Хүснэгт 1-ээс үр дүнгийн хураангуйг харна уу) бүхий 10 метрийн интервалыг сульфидар баяжсан, хальцедон маягийн кварцын эпитеpmаль брекчийн бүс дотор огтолсон.

TND-134 цооногийн үр дүн нь Нээлтийн Бүсийг суналын дагуу 20 метрээр тэлэн, өндөр агуулга бүхий цөм тасралтгүй үргэлжилж буйг баталгаажууллаа. Ингэснээр Алтан Нар ордын нөөцөд эерэг үр дүн авчрах боломж үүсэж байна.

TND-135 цооногийг Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий судлагдаагүй хэсэгт төлөвлөсөн. TND-135 цооног нь 17 г/т алт, 44.7 г/т мөнгө, 0.75% хар тугалга, 1.47% цайрын агуулгатай 17 метр интервал бүхий хар, сульфидар баяжсан эпитеpmаль брекчийг огтолсон. TND-135 цооногийн өрөмдлөгийн үр дүнд Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий цөмийн хэмжээ болон өндөр агуулга үргэлжилж байгааг тодорхойлж, Нээлтийн Бүсийн нөөцийг ирээдүйд нэмэгдүүлэх боломж буйг харууллаа.

TND-136 цооноогоор Нээлтийн Бүсийн баруун өмнөд үргэлжлэлийг шалгахар төлөвлөсөн. TND-136 нь 0.99 г/т алтны агуулга бүхий 2 метр, 0.37 г/т алтны агуулга бүхий 16 метрийн интервалуудыг огтолсон. Эдгээр интервалууд нь Нээлтийн Бүсийн баруун өмнөд хэсэгт илрүүлсэн хамгийн өндөр агуулга бөгөөд баруун урагш чиглэлтэй структурын дагуу нөөцийг тэлэх боломжтойг харуулж байна.

TND-137 цооног нь Хойд Нээлтийн Бүсийн хүдэржилтийг суналын дагуу баруун урагш тэлэх дөт гүний өндөр агуулга бүхий бүсийг шалгахар чиглэсэн. TND-137 цооног нь 2.64 г/т алт, 11.1 г/т мөнгө, 0.66% хар тугалга, 0.43% цайр бүхий 7 метрийн интервалыг огтолсон. Мөн TND-137 цооногийн гүн хэсэгт 1.76 г/т алтны агуулга бүхий 4 метрийн аномаль интервалыг огтолсон нь Нээлтийн Бүсэд хүдэржсэн эпитеpmаль брекчийн хэд хэдэн бүс байгааг дахин баталгаажууллаа.

TND-138 цооногийг Нээлтийн Бүсийн хойд хэсэгт, өмнө нь өрөмдлөг хийгдээгүй талбайд алтны эрдэжилт, агуулгын үргэлжлэлийг судлахаар өрөмдсөн. Цооног нь алтаар эрдэжсэн 3 өөр интервалыг огтолсон бөгөөд үүнд: кварцын штокверк судал, эпитеpmаль брекчид байх 4.68 г/т алт, 50.8 г/т мөнгө, 0.31% хар тугалга, 0.73% цайрын агуулгатай 10 метрийн интервал багтаж байна. TND-138 нь Алтан Нарын нөөцөд эерэгээр нөлөөлөх боломжтой Нээлтийн Бүсийн хойд хэсэг дэх өндөр агуулга бүхий эрдэжилт үргэлжилж байгааг тодорхойллоо. Мөн, Нээлтийн Бүсэд TND-134, TND-101 огтолж буй бүсийн өмнө зүгт урьд нь өрөмдлөг хийж байгаагүй талбайд 70 метрийн турш өндөр агуулга үргэлжилж буйг баталгаажууллаа.

Алтан Нар ордын тухай

Алтан Нар орд нь өдгөө ашиглалтын шатанд шилжихээр эцсийн ТЭЗҮ-ийн судалгаа хийгдэж буй Баян Хөндий ордоос хойд зүгт 16км зайтай оршдог, карбонат-полиметаллт алтны (CBMG) орд гэж үзэж байгаа ба нийт 5.6км урттай гадаргын эрдэсжсэн бүс нь гүндээ болон одоогоор мэдэгдэж буй суналын дагуу нөөц тогтоох боломжтой гэж үздэг. Карбонат-полиметаллт алтны орд нь эпитеpmаль ордын дэд бүлэгт хамаардаг ба Баррик Гоулдын Поргера уурхай (Папуа Шинэ Гвиней), Рио Тинтогийн олборлож байсан Келиан уурхай (Индонези), Лундинын Фрута Дел Норте, Континентал Гоулдын Буритика төсөл (Колумби) зэрэг ордууд нь энэ төрөлд багтдаг. Энэ төрлийн ордууд нь ерөнхийдөө нуман тогтоц (арлан нум г.м.) дахь порфирийн интрузивын дээд хэсэгт тохиолдох ба эрдэсжилт нь 500 гаруй метр гүн үргэлжлэх боломжтой байдаг.

Тусгай зөвшөөрлийн талбайд хайгуул судалгаа хязгаарлагдмал хийгдсэн бөгөөд нөөцийн 90% нь газрын дөт гүнд буюу 150 метрт агуулагдаж байна. Нөөц нь хэтийн төлөв бүхий 18 талбайн 2-т агуулагдаж, суналын дагуу болон гүндээ нээлттэй байна.

2018 оны 5 сарын 7-нд танилцуулсан нөөц*:

- Бодитой нөөц: 317,000 унц алт (2.0 г/т алтны агуулга бүхий), 31,600 тн цайр, 29,000 тн хар тугалга болон 2.35 сая унц мөнгөний нөөц агуулагдаж байна. Боломжтой нөөц: 185,700 унц алт (1.7 г/т алтны агуулга бүхий), 23,700 тн цайр, 22,300 тн хар тугалга болон 865,900 унц мөнгөний нөөц агуулагдаж байна.

**Altan Nar Gold Project Bayankhongor Aimag, Southwest Mongolia NI 43-101 Technical Report, June 21, 2018*

Сүүлийн 2 жилд Компани болон хайгуулын баг нь Баян Хөндий орд дээр бүх нөөц бололцоогоо дайчлан ажилласан бөгөөд энэ хугацаанд Алтан Нарын тусгай зөвшөөрлийн талбайд хязгаарлагдмал хайгуулын ажил хийсэн. Хамгийн сүүлд хийсэн хөтөлбөрөөр (2016 оны төгсгөлд болон 2017 оны эхэнд) Алтан Нарын структурын зангилааг амжилттай өрөмдөж, Алтан Нар дахь хамгийн өндөр агуулга буюу 55.6 г/т алтны агуулга бүхий 14 метрийн интервалыг (TND-101) огтолсон. Тус структурын зангилааг эсвэл дайлэшн бүсүүд (zones of dilation)-ийг тогтоцын хувьд зүүн хойш чиглэлтэй структурын коридор дагуу байх эрдэсжсэн өргөн бүсүүд байна гэж таамаглаж байсан ч саяхан хийгдсэн хянан нягтлах болон ордын загварчлалын ажлын үр дүнгээс харахад нэн өндөр агуулгууд нь давхарга хэлбэрийн бүс үүсгэж байгаа нь ажиглагдсан. Үүнийг эпитеpmаль буцлалтаас үүссэн гэж тооцож байгаа. Эдгээр хүчин зүйлс нь өндөр агуулга бүхий давхарга үүсэх таатай нөхцөлийг бүрдүүлснийг 2019 оны эцэст хийгдсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүн батлах бөгөөд тус ордод болон ордыг агуулах 5.6 км урттай коридорын дагуу хийгдэх ирээдүйн хайгуулын хөтөлбөрийг боловсруулах чиглэл болно.

Дээрх өндөр агуулга бүхий цөм нь өмнө хийгдсэн бага агуулга бүхий нөөцийн блокоос гадна оршиж байгаа бөгөөд Нээлтийн Бүсийн өндөр агуулга бүхий цөмийг тэлээд зогсохгүй, хүдрийн давхаргад өндөр агуулга тасралтгүй үргэлжилж буйг харууллаа. Ингэснээр Алтан Нарын нөөцөд эерэгээр нөлөөлөн, суналын дагуу болон дүүргийн хэмжээнд үргэлжлүүлэн тэлэх боломжийг илэрхийлж байна.

Хар Морь Алтны илрэл

Хар Морь талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд, Баян Хөндий алтны ордоос зүүн-хойд зүгт 4.5 км-т, Алтан Арроу хайгуулын талбайн зүүн-өмнөд зүгт 1 км-т оршдог. Хар Морь талбайг 2019 оны 4-р улиралд кварцын штокверк судлаар зүсэгдсэн массив турмалиныг дээжлэн, 32.9 г/т алтны агуулгатай болохыг тогтоосноор анх нээн илрүүлсэн. 2019 оны 4-р улиралд нэмэлт гадаргуун хайгуул буюу геологийн зураглал, геохимийн судалгааг (чулуун болон хөрсний дээжлэлт) хийсэн бөгөөд үүнээс бш чулуун дээжинд буюу сиенитийн порфирийг зүссэн комб кварц-адуларын судалд 5 г/т-оос 87.8 г/т хүртэлх алтны агуулга илэрсэн. 2019 оны 4-р улиралд гүйцэтгэсэн хайгуулын ажил нь Хар Морь талбайг баруун зүгт 1.5км х 2км болгон тэлснээр зэргэлдээ орших Алтан Арроу алтны хэтийн төлөв бүхий талбайтай залгаа болов.

Улаан Зэс-Алтны хайгуулын талбай

Эрдэнэ Ресурс 51%-ийг эзэмшдэг Улаан хайгуулын талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн чанх баруун талд оршдог. Улаан тусгай зөвшөөрлийн талбай нь газрын гадарга дээр 5км х 4км хэмжээтэй филлик хувирлын (кварц-серицит-пирит) өргөн бүс үүсгэсэн порфирын хэтийн төлөвтэй талбай хэмээн ойлгогддог. 2019 оны 4-р улиралд нийт 702 тууш метрийн өрөмдлөгийн ажил хийн UDH-02 цооногийг 350 метрээс сунган өрөмдөж 640 метр болгон гүнзгийрүүлж хувирлын бүсийн хэтийн төлөвийг нэмж судалсан. Түүнээс гадна дөт гүний хоёр хайгуулын цооног өрөмдөн геофизикийн аномальтай холбоотой байх шаврын хувирлын бүс (UDH-04) болон мөн Улаан талбайн гадаргууд тогтоогдсон хэд хэдэн кварц-турмалины брекчүүдийн нэгийг (UDH-05) шалгахаар өрөмдсөн.

2019 оны 4-р улиралд өрөмдсөн UDH-02 цооногийн үр дүнд вулканик-субвулканик чулуулагт ангидрит-кварц-магнетитын судалжилт ихтэй филлик төрлийн хувирал гүнд үргэлжилж буйг тогтоосон. Тус цооногийг дунджаар 130 ppm зэсийн агуулгатай сениг порфирит 22 метр өрөмдөн хаасан.

UDH-04 цооногоор геофизикийн гажлыг буюу өндөр туйлшрал бүхий хоёр сигналийн хооронд байх өндөр эсэргүүцлийн гажлыг шалгахаар өрөмдсөн. Тус цооног нь бүхэлдээ серицитийн хувирал болон пиритийн хүдэржилттэй агуулагч андезит байсан ба зарим хэсэгт нь турмалины хувирлын бүсүүд болон кварцын судалжилт тогтоогдсон. Геохимийн аномаль тус цооногт илрээгүй.

Улаан тусгай зөвшөөрлийн талбайд шинээр тогтоогдсон, геологийн хэтийн төлөв бүхий турмалины брекчийг судлахаар UDH-05 цооногийг өрөмдсөн. Энэхүү талбай нь ойролцоогоор 850м х 900м хэмжээтэй бөгөөд энэхүү цахиуржсан, серицитийн хувиралтай хэд хэдэн кварц-турмалины брекчийн биетүүдийг зайнаас тандан судлах (хувирлын) судалгаа болон гадаргуун зураглалаар илрүүлсэн. UDH-05 цооног нь гадаргууд үүсгэсэн гарш, геофизикийн өндөр эсэргүүцлийн сигнал дээр үндэслэсэн таамаглагдсан турмалины брекчийн хоолойг судлахад чиглэсэн. UDH-05 нь 140-өөс 202 метрийн (цооногийн төгсгөл) гүнд алт агуулсан кварц-турмалины брекч болон брекч судалтай турмалин-цахиур-серицитийн хувирлын бүс байгааг илрүүлсэн. Алт агуулсан аномаль интервалууд: 1.3 г/т алтны агуулга бүхий 2 метр, 0.29 г/т алтны агуулга бүхий 4 метр, 0.5 г/т алтны агуулга бүхий 2 метр, 0.23 г/т алтны агуулга бүхий 2 метр, 0.15 г/т алтны агуулга бүхий 40 метрийн интервал илэрсэн. Тус аномаль бүсэд >400 ppm хүртэл зэсийн хүдэржилт илэрсэн. Эрдэнэ Ресурсийн техникийн баг нь эдгээр шинэ үр дүнгүүдийг талбайн геологи, геохими, геофизиктэй холбон тайлал хийн, ирээдүйд Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хийгдэх өрөмдлөгийн ажлыг тодорхойлохоор ажиллаж байна.

Хөндий Алтны Дүүрэг

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

2019 оны 10 сард Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн техникийн тайланг (Хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу) танилцуулсан бөгөөд энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндий, Алтан Нар ордын татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалтаар) (“NPV5%”) алтны үнийг \$1,300 ам.доллар/унц байхаар төсөөлөхөд тус бүр \$97 сая ам.доллар, \$24 сая ам.доллараар тооцоологдсон. Баян

Хөндий ба Алтан Нарын дотоод өгөөжийн түвшинг (“IRR”) тус бүр 90%, 42% гэж тооцоолсон. Урьдчилсан ТЭЗҮ-д 0-7 жилд Баян Хөндий ордыг ашиглах ба 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 61,000 унц алтыг илээр олборлох, 7-10 жилд Алтан Нар ордыг ашиглан, 3.46 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 48,000 унц алт олборлохоор төлөвлөж байна. Баян Хөндий ордод уламжлалт нүүрсэнд уусгах боловсруулах үйлдвэрийг байгуулахаар төлөвлөсөн. 2019 оны 8-р сард Баян Хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд компани 2021 оноос эхлэн үйлдвэрлэл эхлүүлэхээр төлөвлөж байна. Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоололд боломжит нөөц агуулсан. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл ихтэй. Эдийн засгийн үр ашиг багатай геологийн нөөцийг үйлдвэрийн нөөц, эдийн засгийн тооцоололд багтаахгүй.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд 4 хайгуулын, 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх баттай мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь Англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>


LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>

KHUNDII GOLD DISTRICT

Three deposits, multiple prospects, limited exploration

Fast tracking to production



THE KHAR MORI GOLD PROSPECT EXPANDED THROUGH Q4 EXPLORATION

ALTAN ARROW GOLD PROSPECT:
Shallow drilling returned multiple high-grade intersections including 2m of 70 g/t Au and 2m of 23 g/t Au

Q4 Rock Sample Results

12.1 g/t Au

87.8 g/t Au

15.3 g/t Au

18.2 g/t Au

32.9 g/t Au

ULAAN
Gold bearing tourmaline breccia intersected in Q4-2019 drilling

KHAR MORI PROSPECT:
Multiple high-grade gold in rock (up to 87.8 g/t Au) and soil samples expand area to ~3km²

BAYAN KHUNDII GOLD DEPOSIT:
1.5 km long soil and rock chip gold anomaly




Rock chip sample

- > 10 g/t
- 5-10 g/t
- 1-5 g/t

• Drill collar

--- Structure



45 g/t GOLD OVER 7 METRE INTERSECTION CONFIRMS CONTINUITY OF THE HIGH-GRADE CORE OF THE DISCOVERY ZONE AND DEMONSTRATES THE POTENTIAL ALONG ALTAN NAR'S 5.6 KM MINERALIZED TREND

**5.6 KM
MINERALIZED TREND**

Exploration Targets
Non-Drill Tested
Gold In Soil Anomaly ±
Geophysical Anomaly

